

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр, Лхагва гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-5

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 6-17

1.Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал 8

2.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ 8-11

3.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/ 11-14

4. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нарын 3 гишүүн 2022.09.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ 14-16

5.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/ 16-17

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
11 дүгээр сарын 29-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл***

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Саранчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 13 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бейсен, Г.Дамдинням, Д.Өнөрболор, Ц.Туваан;
Чөлөөтэй: Ц.Анандбазар.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Саранчимэг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд хэлэлцэх асуудлын 5 дугаарт орсон Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг 1 дүгээрт оруулж, хэлэлцэх нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Б.Саранчимэг: Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13

69.2 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг хэлэлцэхээр болов.

Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 13 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Саранчимэг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалыг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байгаа талаарх танилцуулав.

Танилцуулга болон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Саранчимэг: Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргалыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 3
Бүгд: 10
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Мал эмнэлгийн бодлогын асуудал хариуцсан ахлах шинжээч Х.Алтангэрэл, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Хяналт, баталгаажуулалтын газрын дарга Б.Батсүх, Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсийн дарга Г.Батмөнх, мөн хэлтсийн гаалийн улсын байцаагч Г.Шүрэнчулуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нарантуяа, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Мал эмнэлгийн бодлогын асуудал хариуцсан ахлах шинжээч Х.Алтангэрэл, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Хяналт, баталгаажуулалтын газрын дарга Б.Батсүх, Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсийн дарга Г.Батмөнх, мөн хэлтсийн гаалийн улсын байцаагч Г.Шүрэнчулуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нарантуяа, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Санал, дүгнэлттэй холбогдуулан холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун хариулж, тайлбар хийв.

Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Б.Саранчимэг: Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14

57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал санал хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нарын 3 гишүүн 2022.09.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга И.Батчулуун, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Орчны бохирдол, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн хэлтсийн мэргэжилтэн Б.Мөнхжаргал, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, “Азтай савар” ТББ-ын тэргүүн Ц.Зориглон, мөн ТББ-ын зохицуулагч Э.Бүжинлхам, удирдах зөвлөлийн гишүүн Ц.Болормаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэгийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар хариулж, талбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга И.Батчулуун, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Орчны бохирдол, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн хэлтсийн мэргэжилтэн Б.Мөнхжаргал, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, “Азтай савар” ТББ-ын тэргүүн Ц.Зориглон, мөн ТББ-ын зохицуулагч Э.Бүжинлхам, удирдах зөвлөлийн гишүүн Ц.Болормаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, П.Хулан, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар танилцуулав.

Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Б.Саранчимэг: Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 48 минут үргэлжилж, 19 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 15 цаг 01 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.САРАНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
14 цаг 13 минут.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Саранчимэг: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, 57.9 хувьтай болсон тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний сонгогдсон тойрог, нэрээр нь танилцуулна.

Батсүхийн Саранчимэг 22 дугаар тойрог ирсэн байна. Тилеуханы Аубакир 2 дугаар тойрог ирсэн байна. Жадамбын Бат-Эрдэнэ 4 дүгээр тойрог ирсэн байна. Жигжидийн Батжаргал 14 дүгээр тойрог ирсэн байна. Хаянгаагийн Болорчулуун 7 дугаар тойрог ирсэн байна. Гочоогийн Ганболд 10 дугаар тойрог ирсэн байна. Наянтайн Ганибал 12 дугаар тойрог ирсэн байна. Цагаанхүүгийн Идэрбат 18 дугаар тойрог ирсэн байна. Гомпилдоогийн Мөнхцэцэг 6 дугаар тойрог ирсэн байна. Нанзадын Наранбаатар 11 дүгээр тойрог ирсэн байна. Ганзоригийн Тэмүүлэн ирж байна. Цэвэгдоржийн Туваан 14 дүгээр тойрог орон нутагт ажиллаж байна. Цэдэндамбын Цэрэнпунцаг 9 дүгээр тойрог ирсэн байна. Төмөртоогоогийн Энхтүвшин 8 дугаар тойрог ирсэн байна.

Та бүхэнд хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээр асуудал, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг байгаа.

Хоёрдугаар хэлэлцэх асуудал, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл анхны хэлэлцүүлэг байна.

Гурав дахь нь Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд байгаа.

Дөрөвт, Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг байгаа.

Тавд, Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу. Нэрсээ өгнө үү. Идэрбат гишүүнээр тасаллаа. Ганболд гишүүн саналаа хэлье.

Г.Ганболд: Даргаа тав дахь асуудлаа нэгдүгээр асуудал болгочих. Сүүл рүүгээ ирц хүрдэггүй юм байна лээ тэгэх үү. Тав дахь асуудлаа эхний асуудал болгоод хэлэлцчихье. Нэгдүгээр

асуудал болгоод хэлэлцчихье гэсэн санал гаргаж байна.

Б.Саранчимэг: Идэрбат гишүүн саналаа хэлье.

Ц.Идэрбат: Байнгын хорооны гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Өнгөрсөн 7 хоногт Хэнтий аймгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд орон нутагт ажилласан. Иргэд олон нийтээс энэ өвөлжилттэй холбоотой хүндрэл, бэрхшээлтэй олон асуудлуудыг гаргаж тавьж байна.

Дээрээс нь олон жил, 2 жил бараг яригдлаа даа энэ гурилын үнийн өсөлт гэдэг энэ зүйлийг хүн болгон ярьж байна. Үнэхээр ч би энэ Статистикийн үндэсний хорооноос авсан мэдээ энэ байна л даа. Өнгөрсөн 2020 онд 1300 байсан гурил өнөөдөр 2500 болчихсон килограмм нь. Энэ дээр ер нь бид нар Хөдөө аж ахуйн яам л гээд л цоллоод байдаг. Яг энэ мэргэжлийн энэ яам нь бол энэ газар тариалан эрхлэгчтэйгээ, гурил үйлдвэрлэгчтэйгээ хамтарч л ажиллаж байна шүү дээ. Сайн ургуул, гурил үйлдвэрлэл гээд байдаг. Энэ үйлдвэрлэсэн, тарьсан нөхдүүдийн гурил хуйвалдааны маягаар үнэ өсөж байна уу, үгүй юү гэдэг дээр би Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар хяналт тавих ёстой гэж хуулиараа. Энэ газар ер нь одоо яг энэ асуудал дээр юу хийж байна вэ. Тэгэхээр Байнгын хорооны ирэх 7 хоногийн хурал дээр энэ Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрынхан энэ гурилтай холбоотой асуудал дээр бас ямархуу үйл ажиллагаа хийж байгаа юм бэ гэдгийг нь би сонсьё гэсэн ийм хүсэлтэй байна нэг талаас.

Нөгөө талаасаа өнгөрсөн 7 хоногт Монголбанкнаас энэ төрийн мөнгөний бодлого батлагдсан. Төрийн мөнгөний бодлого батлахад зээлийн хүүг, бодлогынхоо хүүг 13 дээр барьж байгаа. 13 дээр барьж байгаагийн гол шалтгаан бол инфляц нөлөөлж байна. Инфляцын түвшин өндөр байна гэж байгаа. Инфляцыгаа цаашаа судлаад үзэхээр

гадаад хүчин зүйл гэхээсээ илүү дотооддоо үйлдвэрлэж байгаа энэ гурилын үнийн өсөлт чинь инфляцад асар их нөлөө үзүүлээд байгаа юм байна лээ шүү дээ. Монголбанкны тайлбарлаж байгаагаар. Тэгэхээр энэ инфляц өндөр байгаагаас шалтгаалаад бодлогын хүүгээ 13 хувьдаа барьчихаар бизнес эрхлэгч нарт арилжааны зээлүүд нь өндөр хувьтай очоод байна.

Тэгэхээр энэ чинь ганц нэг гурилын асуудал биш энэ Монгол Улсын энэ эдийн засаг, энэ бизнестэй холбоотой асуудлууд бас давхар явж байна гэж ингэж харж байгаа юм.

Нөгөө талаасаа сая иргэд бол, гурилын үнээ ингээд алдчихсан. Одоо хөдөө, гадаа нөхцөл байдал хүндэрч байна. 9 эхлээгүй байхад -30-тай, цас зудын асуудал сум хоорондоо явж чадахаа больж байгаа. Энэ цаг үед энэ тэжээлийнхээ асуудлыг битгий энэ гурилын үнэ шиг алдчихаарай гэдэг зүйлийг малчид ярьж байна шүү дээ. 22 мянга байсан тэжээл цас орсон сургаар 28 болж байна гэж байна.

Гэтэл Монгол Улс хивээ гадагшаа экспортлож байгаа гэсэн ийм юм байгаад байгаа юм. Үнэхээр хангалттай болоод экспортлоод байгаа юм уу, дотор байгаа нь үнээ эсвэл өсгө гэж бодоод экспортлоод байгаа юм уу. Эсвэл экспортлож байгаа нь үнэн юм уу, худал юм уу гэдэг дээр асуумаар байгаа юм. Нэг ийм зүйл.

Хоёрдугаарт, энэ гадаа л 1 хүн, би намар бас 9 сард хэлж байсан даа 150 хоног боллоо гээд. Энэ чинь зуслаа, намаржлаа, өвөлжлөө, одоо асуудал байдаг бол ишидээд, хуулийн хүрээнд нь болох, болохгүйг нь хэлээд энэ асуудлаа яахгүй юм уу. Би намар хэлж байсан 9 сард. Одоо бас энэ чинь бас хэцүү л харагдаад байх юм байна шүү дээ гэж бас хэлье гэж ингэж бодож байна. Баярлалаа.

Б.Саранчимэг: Хэлэлцэх асуудалтай холбогдуулж гишүүд саналаа хэллээ. Тэгэхээр Идэрбат гишүүний хэлсэн санал дээр манай Байнгын хорооны ажлын ажлын албаныхан бас бэлтгэл ажлаа хангаад дараагийн Байнгын хороогоор хэлэлцэх боломжтой. Тэгэхээр энэ дээр бас манайхан хариу өгөөд, яг энэ мэдээллийг сонсох боломжтой байгаа.

Ганболд гишүүний саналаар санал хураалт явна. Тэгэхээр энэ Байнгын хорооны даргын асуудлыг бас Монгол Ардын намын зүгээс бас...аар явуулах ийм санал гаргаад өнөөдөр бас энэ асуудал орж ирж байгаа. Тийм учраас энэ саналыг тав дахь хамгийн сүүлийн асуудал биш эхний асуудал болъё гэсэн санал байгаа учраас эхний асуудалд оруулъя гэсэн саналтай гишүүд санал хураалт явуулъя. Тэгэхээр эхний асуудалд оруулъя гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөв зөв, хүүе би хөөш хөөш. Протокол дээр би дэмжсэн шүү. Энд сая буруу яаж байгаад. Эхний асуудалд оруулъя. Тэгэхээр хэлэлцэх асуудлаа баталъя гэсэн томъёоллоор санал хураалт, санал хураалт явуулахгүйгээр эхний асуудалд оруулаад явуулъя. Би өөрөө танилцуулчихъя.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэж эхэлъе.

Тэгэхээр Байнгын хорооны даргын танилцуулгыг та бүхэнд бас танилцуулж байя. Батжаргал Төв аймгийн Зуунмод сумын 2 дугаар дунд сургуулийг төгссөн. 90 онд Улсын Их сургуулийн Банкны эдийн засагч, 96 онд Удирдлагын академийн Төрийн удирдлагын менежерийн мэргэжилтэй. Төв аймгийн Баян-Өнжүүл сумын “Хаан” банканд эдийн засагч, Баян-Өнжүүл сумын захиргаанд орлогч дарга, Баян-Өнжүүл сумын Засаг даргын орлогч, Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газарт Байгаль орчны хяналтын байцаагч, Баян-Өнжүүл сумын иргэдийн

Төлөөлөгчийн хурлын дарга, Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн дарга, аймгийн Монгол Ардын намын хорооны дэд дарга, Төв аймгийн Засаг дарга гээд ажиллаж байгаа гэсэн ийм тодорхойлолтыг ирүүлсэн байна.

Тэгэхээр өөр Батжаргал гишүүнээс гадна өөр нэр дэвших саналтай гишүүд байна уу. Алга байна. Тийм учраас нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд байна уу. Алга уу.

Саналтай гишүүд байна уу. Байхгүй байна.

Жигжидийн Батжаргалыг дэмжъе гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

76.9 хувиар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Жигжидийн Батжаргалыг сонгохыг дэмжлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Идэрбат танилцуулна. Дараагийн асуудал руугаа оръё.

14.24 цаг

Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсэг орж ирж байна тээ. Энэ анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг бүх гишүүдэд энэ материалыг тараасан байгаа.

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та

бүхэнд танилцуулъя. Ц.Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Э.Цолмонжаргал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Б.Болдбаатар Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга, Б.Батсүх Мал эмнэлгийн ерөнхий газрын Хяналт, баталгаажуулалтын газрын дарга, Х.Алтангэрэл Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал эмнэлгийн бодлогын асуудал хариуцсан ахлах шинжээч, Г.Батмөнх Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсийн дарга.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Ж.Бат-Эрдэнэ танилцуулна. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд гадаад орны мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтын байгууллагатай амьтан, ургамал эхнийхийг нь гээд байсан чинь яасан бэ.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шинжилгээний шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн чуулганы нэгдсэн

хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2023 оны 12 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг, хэллэг, дэс дараалаад бүтцийн шинжтэй засварыг хийж төсөлд тусгасан бөгөөд нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт төслийг бэлтгэлээ.

Хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг та бүхэнд тараасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Баярлалаа.

Б.Саранчимэг: Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн

танилцуулгатай холбогдуулж асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Ганибал гишүүн нар тасаллаа. Ганибал гишүүн асуултаа асууя.

Н.Ганибал: Бүгдэд нь өдрийн мэнд. Ер нь Монголын мал аж ахуйн салбарт энэ өвөлжилт маш хүндээр тусахаар байна. Энэ дээр бүгдээрээ л ярьж байна. Ямар ажлууд авч хэлэлцэж байгаа талаар бас та бүхнээсээ бас тодорхой асуулт асуумаар байх юм.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт одоо ороод эцэслэгдлээ. Махны экспортын асуудлууд, хяналтын энэ асуудлууд, дэлхийд бид бүхэн ямар ч байсан дотоодынхоо асуудлыг бүрэн шийдлээ гэж ойлгож байгаа юм. Энэ хууль эцэслэгдэн батлагдаад бид нарт экспортын баримжаатай экспорт хийх тэр боломжууд маань ер нь яаж нэмэгдэх юм бэ. Сайд, дарга нар гадаад, дотоодод яваад л олон газар хяналтын гэрчилгээ тохирлоо ингээд авч өгөх асуудлуудаа шийдэж байна гээд л яваад байдаг. Бодит нөхцөл байдал дээр өнөөдөр бас махны экспорт маань 2 улсаасаа илүү цааш нь гарч чадахгүй л харагдаад байгаа. Энэ дээр ер нь ямар боломжууд цаашид байна вэ. Тодорхой цаг хугацаатай ажлууд юу байна. Одоо мал амьтны, мал эмнэлгийн 100 жилийн ойтой холбогдуулаад саяхан мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын экспертүүд бас тодорхой удирдлагууд ирчихсэн уулзалт хийгээд харагдаж байна. Энэ хүмүүстэй өнөөдөр зөвхөн баярын асуудал яриад байна уу, өнөөдөр бид бүхний өмнө тулгамдаад байдаг олон улсын мал эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага, Монголын мал аж ахуйн салбарын энэ хянан баталгаажуулалтын ажлууд, эрүүл бүс зарлах тэр хяналтын ажлууд нь ямар түвшинд явж байгаа вэ. Энэ талаараа ямар нэгэн ахиц гарсан уу. Энэ талаар бас асуумаар санагдаж байна.

Дээр нь ер нь малчид маань их хэмжээний мах, мал нядалгаанд

оруулчхаад махны үнэ, хани бодит тогтворжсон тэр цаг хугацааг хүлээгээд хадгалалтын байдалтай байж байгаа. Энэ дээр ямар үйл ажиллагаа хийх гэж байна вэ. Зүгээр миний бодохоор энэ махны үйлдвэрүүдийн эргэлтийн хөрөнгийг нэн яаралтай бас тэр хувь хүнсний хувьсгалын хүрээнд хийгдээд байгаа бага хүүтэй зээлийн тэр боломжоор нэн яаралтай хангаж, богино хугацааны энэ боломжийг нээх энэ ажиллагаа ер нь ямар шатад явж байна. Энэ дээр бас асуулт асууя.

Ер нь өнөөдрийн орон нутгуудад байгаа махны үйлдвэрүүдийн хүчин чадал маань яг нядалгааны хүрээнд хангалттай байж чадахгүй байна. Өнөөдөр 1 аймаг дээр, 1 сум дээр хийж байгаа бодын нядалгаа дээр маш их хэмжээний очер дарааллууд үүсчихсэн, хүлээлтэд орчихсон энэ дээр бас хээрийн бой зохион байгуулах юм уу, хүн хүч багатай энэ малчид дээрээ бас энэ мал нядлах, малаа эцэж турахаас нь өмнө нядалгаанд оруулах энэ ажиллагаа дээр ер нь орон нутгуудтай зохион байгуулалтын ажлууд хийж байна уу гэсэн энэ асуултуудыг асууя.

Б.Саранчимэг: Танилцуулгатай холбогдуулж асуулт асуух ёстой. Энэ дээр нэмээд Бат-Эрдэнэ гишүүн хариулаад, дараа нь Болорчулуун сайд хариулчихъя. Болорчулуун сайд хариулъя.

Х.Болорчулуун: Хуулиас гадуур л юм асууж байна л даа. Яах вэ хуулийн хэлэлцүүлэг. Энэ махны экспортын талаар асууж байна. Мах өнгөрсөн жилтэй харьцуулахад экспортод сайн гарч байгаа. 4 дахин их гарсан өнгөрсөн жилийнхээс. Одоогийн байдлаар 70 мянган тонн мах гараад байна.

Ер нь цаашидаа бид нар махыг тэр түүхийгээр нь чанаад, амьдаар бүхий л хэлбэрээр гарах ёстой. Тэгэхдээ амьдаар гарах дээр бол тодорхой хонь болон ямааныхаа 10 хүртэл хувийг гэдэг ч юм уу энийг бас бид нар Хүнсний аюулгүй байдлын зөвлөлөөр бас ярина гэсэн ийм

бодолтой байгаа. Ганцхан Дорноговиор амьдаар гарч байгаа. Баруун, зүүн бүсээрээ бас амьдаар зөвхөн хонь, ямааг гаргах нь зүйтэй гэсэн ийм ерөнхий бодлоготой байгаа гэдгийг хэлье. Гаргана гэсэн. Тэгэхгүй бол малчид бас мал мах хямд байна, борлогдохгүй байна гэсэн асуудал явж байна.

Тэгэхдээ бид нар чинь яг өөрийн чинь түрүүний хэлдгээр мал, амьтны дэглэм бүхий эрүүл бүсээс олон улс бол мах авдаг, хамгаалагдсан аж ахуйгаас үнэ цэнтэй авна. Тэрнээс биш зүгээр бэлчээрийн малыг, малын махыг 3.5-4 доллароор авч байхад, үсрээд 4.5 доллар авч байхад яг ийм эрүүл бүсийн мал нугарсан нь илүү үнэтэй байдаг гэдгийг бас хэлье. Энэ дээр бол эрүүл бүс, хамгаалагдсан аж ахуйн талаар бас ажиллаж байгаа. Хамгаалагдсан аж ахуйн тухай стандартыг батлуулах ийм бодолтой ажиллаж байгаа гэдгийг бас хэлье.

Тэр махны үйлдвэрүүдийн хүчин чадал, хангалт хөдөөгүүр хангалттай биш үнэн. Тэгэхдээ хээрийн бой иргэд хийж байна. Тэрнээс биш хээрийн бой хийнэ гээд төрөөс, яамнаас ч юм уу янз бүрийн нэмэлт хүч гаргаад хувийн малын бой хийхэд оролцоод байх шиг асуудал байхгүй гэдгийг 2 улсад, хөрш 2 улсад биш шүү. Ер нь нийт 15, 10 гаруй улсад ингэж махны экспорт явагдаж байгаа. Гэхдээ мэдээж Хятад улсад их дийлэнх нь байгаа гэдгийг бас хэлье.

Б.Саранчимэг: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Зарчмын зөрүүтэй санал байхгүй байгаа учраас энэ Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Эцсийн хэлэлцүүлэг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулна. Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа орёё.

14.35 цаг

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсэг өмнөх бүрэлдэхүүнээрээ байгаа, хэвээрээ байна. Тэгэхээр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл Хууль, тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоол уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг хэлэлцэн баталж болно гэж заасны дагуу Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгээс дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг бэлтгэсэн байгаа. Тэгэхээр энэ танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Ж.Бат-Эрдэнэ гишүүн танилцуулна. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл гадаад орны мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтын байгууллагатай хамтран амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл мэнд, хорио цээрийн нөхцөлийг тохиролцох, гэрчилгээ олгох чиг үүргийг гаалийн байгууллагаас хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тус тус шилжүүлэхээр тусгасан.

Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл мэнд, хорио цээрийн нөхцөл, гаалийн байгууллагаас олгож байгаа экспортын гэрчилгээ буюу олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ, ургамлын хорио цээрийн гэрчилгээний загварыг худалдааны түнш улс орнуудын эрх бүхий байгууллагатай харилцан тохиролцсоны үндсэн дээр амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлож импортлодог. Иймээс амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл мэнд, хорио цээрийн нөхцөл, гэрчилгээний загварыг худалдааны түнш улс орнуудын эрх бүхий байгууллагатай шинэчлэн тохироход тодорхой цаг хугацаа шаардлагатай бөгөөд экспорт, импортын үйл ажиллагааг тасралтгүй тогтвортой явуулах нөхцөлийг хангах зорилгоор өмнө тохиролцсон нөхцөл экспортын гэрчилгээний загварыг мөрдөх тухай зохицуулалтыг хуульд тусгах шаардлагатай байна.

Түүнчлэн экспортлох амьтан, ургамлын түүхий эд, бүтээгдэхүүнд олгох ургамлын хорио цээрийн гэрчилгээ, олон улсын мал эмнэлгийн гэрчилгээний загварыг импортлогч улс орны эрх бүхий байгууллагатай шинэчлэн тохирсны дараа хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон мал, амьтны эрүүл

мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гэрчилгээг олгох чиг үүргийг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэгт заасны дагуу амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх хориод цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхэнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Саранчимэг: Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа. Дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг та бүхэнд тараасан байгаа. Энэ хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Нэрсээ өгье. Ганибал гишүүнээр тасаллаа. Ганибал гишүүн асуултаа асууя.

Н.Ганибал: Бид нар энэ экспортын асуудлууд дээр ер нь том бодлогын зураглалаа гаргахгүй яваад байна. Энэ сая Засгийн газар саяхан гаргасан эрүүл бүсийн газруудыг товлоод гаргасан. Харамсалтай нь тэнд нь яг экспортын зорилготой биш хаа хамаагүй газруудад мал, амьтны эрүүл бүс байгуулах, амьдаар нь экспортод гаргах тийм бүсүүдийн асуудал гаргаад байгаа байхгүй юу. Хөвсгөл аймагт тэр ямар хэрэгтэй юм, заавал тэр Хэнтий аймгийн тэр Чандаганы тал дээр эрүүл бүс байгуулах ямар шаардлага байгаа юм. Уг

нь Монгол Улсын экспортод гаргах баримжаат хэд хэдхэн бүс нутгууд боомтууд байгаа. Эд нарыгаа бас заагаад, тэр дээрээ үйл ажиллагаагаа эхлүүлээд явбал илүү бодитой үйл ажиллагаа болно. Тэрнээс юу гэдэг юм хэн нэгэн гишүүн сонгогдсон гишүүн өөрийнхөө тойрогт хаа хамаагүй газар эрүүл бүс байгуулаад бид нар экспорт хийх гэж байгаа гээд яриад явах, бодит ажил болох хоёрын хооронд асар их зөрүү байгаа. Энэ дээр бас Засгийн газар, сайд энэ дээр бас илүү анхаармаар байна.

Тэгэхээр энэ бодит малынхаа тоо толгой, тэгээд экспортын гаргаж болох тэр баруун бүсдээ нэгийг, зүүн бүсдээ нэгийг, зүүн бүсдээ бол Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум дээр байрлах Бичигтийн боомтыг түшиглээд мал, амьтны эрүүл бус байгуулах энэ боломж бүрэн байгаа. Харамсалтай нь яг тээр хол Хөвсгөлд байгуулах ямар шаардлага байгаа юм. Үнэхээр Оросын Холбооны Улс руу мах гаргах гээд байгаа юм уу, эрүүл бүс тэнд шаардлагатай байгаа юм уу энэ асуудлуудаа ер нь эхлээд маш тодорхой зураглалаа гаргаад, түүн дээрээ Засгийн газар энэ шийдвэрүүдээ гаргаад энэ экспортынхоо асуудлыг зөв тийш нь залгахгүй бол энэ болохгүй байна.

Тэгэхээр энэ удаа бас энэ хууль нь гараад байдаг, боломж нь нээгдээд байдаг харамсалтай нь яг бодит ажил болохдоо завхраад байгааг л хэлмээр санагдаж байна.

Б.Саранчимэг: Гишүүд асуулт асууж дууслаа. Болорчулуун сайд хариулна. Болорчулуун сайд хариулъя.

Х.Болорчулуун: Энэ олон улсад мах, махны экс экспорт хийхдээ мал, амьтны дэглэм бүхий, мал мал эмнэлгийн дэглэм бүхий эрүүл бүс, эс үгүй бол хамгаалагдсан аж ахуй гэж 2 янз байгаа юм л даа.

Хамгаалагдсан аж ахуй гэдэг бол багахан хэмжээний 1 аж ахуй юм уу, 2 аж ахуйн хэмжээнд бага аж ахуй газар нутагтай, энэ бас тусдаа дүрэм, журамтай. Эрүүл бүс бол бүр 1 аймгийнх, 2, 3 аймгаар. Баруун 3 аймаг эрүүл бүс. Бид нар баруун 7 гээд чадаагүй. Ер нь баруун 3 аймгийг ингэх боломжтой. Хөвсгөл аймаг бол тэр голоороо тэр Эг-Үүрийн гол билүү түүгээрээ яагаад 6, 7 сум нь орсон байсан юм. Аймаг нь өөрөө бид ер нь био, эрүүл эко аймаг болно. Аймгаараа мал, амьтны дэглэм бүхий эрүүл бүс болмоор байна гэсэн бичиг тоот иргэдийн хурлаараа гаргаад, наашаа ирүүлээд бичиг тоот өгсөн. Үүний дагуу Хөвсгөлийг бол тэр чигээр нь эрүүл бүс болгох ийм чиглэлтэй байгаа. Хөвсгөл өөрөө үхрийн тоогоор бол 1, 2-т ордог. Улсдаа Оросын Холбооны Улс руу 2 боомтоор экспортод гаргах ийм боломжтой аймаг. Зөвхөн Хятад гаргана гэх гэсэн асуудал байхгүй.

Ер нь бид ялангуяа малынхаа тэр тусмаа үхрийнхээ бүртгэл хяналтыг сайн хийж ингэж байж л гадагшаа өндөр үнэтэй, эрүүл мах гаргах ийм боломжтой юм. Энэ бол олон улсын шаардлага нь тийм юм гэдгийг хэлье. Ялангуяа Хятадууд бол бас мал, мах авахдаа ялангуяа амьд мал энэ тэр дээр бол эрүүл бүс бүхий газраас, эс үгүй бол хамгаалагдсан аж ахуй бүхий газраас амьд мал авна гэсэн тийм дотоодын өөрөө хууль, дүрэмтэй юм байна лээ. Энэ мал, мах авах улсуудын шаардлагын дагуу л энэ мал, махаа бас бид нар бас эрүүл болгож экспортод гарах ийм учиртай. Яах вэ үнэ энэ жилийн хувьд бол махны экспорт сайн байна. Өнгөрсөн жил 16 мянган тонн байсан бол энэ жил 70 мянга хүрчхээд бараг 80 мянга хүрэх байх оны эцэст. Ер нь энэ хуучин 18 оны тэр рекордыг эвдэх шинжтэй байгаа. Тэгэхдээ үнийн хувьд бас чамлалттай бай байгаа гэдгийг бас хэлье. Өөр юм хэлээгүй, асуугаагүй байх аа.

Б.Саранчимэг: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч

дууслаа. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна. Бат-Эрдэнэ гишүүн санал гаргая гэж байна. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг хэлэлцэж дуусаж байх шиг байна. Энийг Улсын Их Хурлын чуулганаар анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэсэн зарчмын санал оруулж байна. Анхны хэлэлцүүлгээр баталъя гэж ийм санал оруулж байна.

Б.Саранчимэг: Горимын санал гарч байна. Тэгэхээр бид нар санал хурааж байж шийдэх ёстой. Дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй бол энэ хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимоор одоо санал хураалт явуулна.

Найруулгын шинжтэй санал байна гээд Батжаргал гишүүн хэлж байна. Батжаргал гишүүний микрофоныг өгье. Микрофонд, протоколд бүртгүүлж оруулъя.

Ж.Батжаргал: 1 дүгээр заалт дээр гэрчилгээнийхээ загварыг батлах ёстой юу гэдэг асуудал байгаа юм. Тэгэхээр баталж гэдэг үг орхигдсон юм биш биз гэж ажлын хэсэг анхаараарай гэж.

3 дугаар заалт дээр нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль байхгүй юу. Тэр хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөх юм энэ журмын хуулийг. Тэгэхээр хууль гэдэг үг нь орхигдчихсон байна лээ. Найруулгын хувьд нь анхаараарай гэж.

Б.Саранчимэг: Найруулгын саналыг нь аваад, дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя. Анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.1 хувиар санал дэмжигдлээ. Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа. Дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ танилцуулна. Энэ асуудал хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа орёе.

14.47 цаг

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган энэ эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг та бүхэнд, Улсын Их Хурлын гишүүдэд тараасан байгаа. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж ажлын хэсгийг оруулаарай. Ажлын хэсэг хэлэлцэх асуудалтай холбогдуулж ажлын хэсгийнхийг манай ажлын албаныхан дууд даа.

Эцсийн хэлэлцүүлэг бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар танилцуулна. Ажлын хэсгийнхнийг дараа нь танилцуулчихъя. Цогтбаатар гишүүний микрофоныг өгье. Цогтбаатар гишүүний микрофоныг өгье дөө. Ороогүй та дахиж аваад, гараад.

Д.Цогтбаатар: Байнгын хороон дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр, Нямбаатар, Сүхбаатар нараас 2022 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг 2023 оны 11 дүгээр сарын 16-наас 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх ажлын хэсгээс болон Улсын Их Хурлын гишүүн Туваанаас гаргасан зарчмын зөрүүтэй 53 санал, найруулгын 1 саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналыг төсөлд шигтгэсэн хувилбарыг та бүхэнд тараасан байгаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгээс гаргасан саналыг хэлэлцэн ишийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Саранчимэг: Цогтбаатар гишүүнд баярлалаа. Та бүхэнд Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй төслүүд дээр ажиллаж байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

И.Батчулуун Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, Б.Мөнх-Эрдэнэ Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Орчны бохирдол, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга, Б.Болдбаатар Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга, Ц.Гантөмөр Нийслэлийн мал эмнэлгийн газрын Мал, амьтны эрүүл мэндийн хэлтсийн дарга, Зориглон “Азтай Савар” ТББ-ын тэргүүн, Бүжсинлхам “Азтай савар” ТББ-ын зохицуулагч, Болормаа “Азтай савар” ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүн,

Цэрэнханд Монгол банхар судлалын төвийн үүсгэн байгуулагч, Наранбаяр Монголын нохой судлалын холбооны тэргүүн.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулж асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Нэрээ өгөөрэй. Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа. Мөнхцэцэг гишүүн асуултаа асууя.

Г.Мөнхцэцэг: Бид бас энэ хуулийнхаа нэр томьёо, дээрээс нь бас энэ найруулгаа бас нэлээн харахгүй доторх юмнуудаа бас хэтэрхий чухалчлаад үзсэн юм уу гэж бас ингэж харагдаж байгаа юм. Түрүүн бас энэ Батжаргал гишүүн хэлээдэх нь лээ. Зарим юман дээр бас хууль энэ тэр гээд ийм нэр юманд үг, үсэг юмнууд орхигдчихсон байна гээд тэрэнтэй адилхан бас энэ 4 дүгээр бүлэг дээр ийм нэр байгаад нэр томьёо байгаад байна л даа. Эзэнгүй амьтантай холбоотой харилцаа гэж яг юу гэж ойлгох юм. Энийг тэгэхээр ийм ойлгомжгүй нэр томьёо байна уу гэж хараад байна. Үүнийгээ энэ чинь сольж болох билүү, дахиж найруулж оруулж өгч болох билүү. Жоохон ойлгомжтой болгож орж ирж болох болов уу эцсийн хэлэлцүүлэг. Ийм нэр томьёо юмнуудыг бас хараад янзалчхаж болохоор бол бас өөрчилчихмөөр ч юм уу. Энэ чинь их тийм айхтар агуулгын хувьд өөрчлөгдөхгүй. Гэхдээ зүгээр яг энэ чигээрээ явахаар бас тийм бууж өгөхгүй л байна л даа. Тийм.

Б.Саранчимэг: Ажлын хэсгийн ахлагч Цогтбаатар дарга хариулах уу.

Д.Цогтбаатар: Энд 3.1.4 дээр энэ чинь энэ хуулийнхаа хүрээнд хэрэглэж байгаа томьёонуудаа заагаад өгчихсөн байгаа. 3.1.4 дээр эзэнгүй амьтан гэж юу вэ гээд “бусдын асран хамгаалалт, хараа хяналтад байхгүй гэрийн тэжээвэр амьтныг хэлнэ” гээд заагаад өгчихсөн байгаа юм. Энэ дээр яах вэ эзэнгүй амьтантай холбоод бүлгийн том гарчиг

болохлоор энэ аль болох товчлол хийж өгсөн байгаа шүү дээ.

Гэхдээ би таны бас юу ярьж байгааг ойлгож байна. Энэ буруу мушгиж ойлгох гээвэл буруу мушгиж ойлгохоор байна шүү дээ. Түүнээс энэ яг хуулийнхаа хүрээнд томъёогоо заагаад өгчихсөн учраас эзэнгүй амьтантай холбоотой харилцаа гэдэг чинь эзэнгүй амьтан энэ нийгэмд бидний дунд явж байна шүү дээ. Энэнээс үүдэлтэй захиргааны энэ амьтныг жишээлбэл хүн хазах гээд байна эндээс холдуулж өгөөч гээд л нийгмийн харилцаа үүсэж байна шүү дээ. Энэ нийгмийн харилцааг яаж зохицуулах вэ төр, захиргааны байгууллагуудтайгаа яаж харьцах вэ, иргэд хоорондоо яаж харьцах вэ, ямар эрх зүйн харьцаа үүсэх вэ тэр тухай л зохицуулалтууд орж ирсэн бүлэг заалт байгаа юм.

Б.Саранчимэг: Ажлын хэсгийн даргад баярлалаа. Тэгэхээр энэ эцсийн хэлэлцүүлэг явж байгаа. Энэ дээр бас өмнө нь нэлээн олон удаа хэлэлцэгдсэн байгаа. Тэгэхээрээ гишүүд асуулт асууж, хариулт авлаа.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Эцсийн хэлэлцүүлэг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар танилцуулна. Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа Гэрийн тэжээвэр амьтантай холбоотой энэ. Дараагийн асуудал руу оръё.

14.55 цаг

Тэгэхээр энэ Гэрийн тэжээвэр амьтантай холбоотой зөвшөөрлийн асуудлууд чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай чуулганы

хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг үндэслэн боловсруулсан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсэг өмнөх бүрэлдэхүүн хэвээрээ байгаа. Тэгэхээр ажлын хэсгээс Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг бэлтгэсэн байгаа. Энэ танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Цогтбаатар танилцуулна.

Д.Цогтбаатар: Байнгын хороон дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр, Нямбаатар, Сүхбаатар нараас 2022 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг 2023 оны 11 дүгээр сарын 16, 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хороонд шилжүүлсэн.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх ажлын хэсгээс гаргасан нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх эзэнгүй амьтанд түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэхэд мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зөвшөөрөл олгохтой холбоотой зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд үндэслэн боловсруулсныг та бүхэнд танилцуулж байна.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Саранчимэг: *Цогтбаатар гишүүнд баярлалаа. Хуулийн төслийг та бүхэнд тараасан байгаа. Тэгэхээр Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Асуулт асуух гишүүд алга байна.*

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй байгаа учраас энэ төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналаар санал хураалт явуулъя. Энэ санал ажлын хэсгийн дарга санал гаргая гэж байсан шүү дээ. Одоо гаргачих.

Д.Цогтбаатар: *Байнгын хороон даргаа нэгэнт энэ асуудал дээр зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас энийг суурь хуулийнхаа эцсийн хэлэлцүүлэгтэй шүүд хамтатгаад явах горимын санал байна.*

Б.Саранчимэг: *Горимын санал гаргаж байна. Тэгэхээр горимын саналаар анхны хэлэлцүүлгээр нь эцэслэн батлахаар санал оруулж байна.*

Д.Цогтбаатар гишүүний гаргасан саналын дагуу санал хураалт явуулъя. Санал хураалт анхааралтай өгөөрэй.

54.5 хувиар санал дэмжигдлээ. Энэ асуудлыг хэлэлцэж дуусааж байна.

Чуулганы хуралдаанд танилцуулгыг Цогтбаатар гишүүн танилцуулна.

Өнөөдөр Байнгын хороогоор хэлэлцэх асуудлууд хэлэлцэгдэж дууслаа. Хуралдаа идэвхтэй оролцсон Улсын Их Хурлын эрхэм гишүүд болон ажлын хэсгийнхэнд баярлалаа. Хурал дууслаа.

15.01 цаг

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР**